



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/36/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт хот 2022 он	Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
	Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
	Аудитын менежер: Г.Даваа
	Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
	Аудитор: Б.Ганцэцэг
	Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Албан шаардлага	15
4.2 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

№ 57
танай _____ -ны № _____ -т

СҮХБААТАР АЙМГИЙН АСГАТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.ЛХАГВА-ОЧИР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асгат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,957,121.95</u>	<u>26,336,119.95</u>
33	АВЛАГА	00.00	1,364,480.00
335	Бусад авлага	00.00	1,364,480.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,364,480.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,957,121.95	24,971,639.95
351	Түүхий эд материал	1,082,800.00	1,704,000.00
35130	Эм боох материал	1,082,800.00	1,704,000.00
354	Хангамжийн материал	16,874,322.00	18,267,640.00
35410	Бичиг хэргийн материал	365,000.00	331,500.00
35420	Аж ахуйн материал	7,212,204.00	8,685,890.00
35440	Түлш, шатах тослох материал	211,218.00	251,350.00
35460	Хүнсний материал	232,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	8,853,900.00	8,998,900.00
35600	Мал амьтад	4,999,999.95	4,999,999.95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>641,760,675.94</u>	<u>669,695,876.88</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	641,760,675.94	669,695,876.88
392	Биет хөрөнгө	631,196,675.94	659,131,876.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	512,186,631.81	561,958,292.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	-56,983,905.84	-92,295,096.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,677,000.00	203,149,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-79,317,523.56	-185,476,999.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	60,136,300.00	104,343,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,762,037.46	-47,915,529.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,789,459.13	70,634,859.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,745,413.01	-53,158,696.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	183,506,941.00	216,645,554.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-109,340,776.13	-118,903,107.77
39217	Ном	50,000.00	150,000.00
393	Биет бус хөрөнгө	10,564,000.00	10,564,000.00
39301	Програм хангамж	215,000.00	215,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-215,000.00	-215,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,564,000.00	10,564,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>664,717,797.89</u>	<u>696,031,996.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>365,800.00</u>	<u>823,427.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	365,800.00	823,427.00
413	Өглөг	365,800.00	823,427.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	823,427.00
4136	Бусад өглөг	365,800.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	365,800.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>664,351,997.89</u>	<u>695,208,569.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	664,351,997.89	695,208,569.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	268,617,929.00	268,617,929.00
51101	Өмч: - төрийн	268,617,929.00	268,617,929.00

512	Хуримтлагдсан үр дүн	216,254,971.32	247,111,543.26
51210	Өмнөх үеийн үр дүн	216,254,971.32	216,254,971.32
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	30,856,571.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	179,479,097.57	179,479,097.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	664,717,797.89	696,031,996.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	457,527,006.00	590,009,190.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,284,804.00	98,061,013.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,935,804.00	84,261,013.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,935,804.00	84,261,013.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,935,804.00	84,261,013.00
122	Тусламжийн орлого	4,349,000.00	13,800,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	4,349,000.00	13,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,242,202.00	491,948,177.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,861,902.00	50,193,977.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,366,000.00	3,198,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,260,902.00	39,408,977.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,235,000.00	7,587,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	390,380,300.00	441,754,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	390,380,300.00	441,754,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	407,939,353.14	508,962,587.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407,939,353.14	508,962,587.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,745,363.14	490,855,444.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,970,633.90	249,862,523.14
210101	Үндсэн цалин	172,284,506.75	172,470,074.94
210102	Нэмэгдэл	53,997,604.19	39,026,631.44
210104	Урамшуулал	7,177,840.00	12,695,262.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,510,682.96	25,670,554.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,916,325.10	32,193,500.00
210201	Тэтгэврийн даатгал	20,392,203.60	22,317,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,387,331.65	2,469,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,903,145.10	1,975,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	475,786.55	493,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,757,858.20	4,937,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,863,106.00	17,324,890.00
210301	Гэрэл, цахилгаан	5,288,317.00	6,661,512.00
210302	Түлш, халаалт	11,574,789.00	10,603,378.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	60,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,501,655.00	27,008,176.00

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	4,672,337.00	4,622,830.00
210402	Тээвэр, шатахуун	21,138,118.00	17,201,922.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,145,000.00	2,300,000.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,046,200.00	2,763,424.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	380,000.00	00.00
2105	Нормативт зардал	2,878,580.00	7,132,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	859,000.00	6,900,000.00
210502	Хоол, хүнс	2,019,580.00	232,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	898,850.00	29,099,082.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	501,700.00	4,440,300.00
210604	Урсгал засвар	397,150.00	24,658,782.00
2107	Томилолт, зочны зардал	1,158,344.00	1,962,262.50
210702	Дотоод албан томилолт	1,158,344.00	1,962,262.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,804,300.00	54,518,631.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,804,300.00	54,518,631.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,753,569.14	71,754,379.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,982,000.00	3,344,637.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,771,569.14	68,409,741.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,193,990.00	18,107,143.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,559,330.00	16,511,420.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,751,980.00	5,953,320.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,878,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,043,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,764,050.00	4,679,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,634,660.00	1,595,723.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,634,660.00	1,595,723.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>49,587,652.86</u>	<u>81,046,603.09</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,624,245.76	50,190,031.15
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,624,245.76	50,190,031.15
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,624,245.76	-50,190,031.15
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>41,963,407.10</u>	<u>30,856,571.94</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,705,929.00	20,849,780.00	210,056,392.02	00.00	490,612,101.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,705,929.00	20,849,780.00	210,056,392.02	00.00	490,612,101.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,290,753.28	00.00	24,290,753.28
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,617,929.00	179,479,097.57	216,254,971.32	00.00	664,351,997.89
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,617,929.00	179,479,097.57	216,254,971.32	00.00	664,351,997.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,617,929.00	179,479,097.57	216,254,971.32	00.00	664,351,997.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	30,856,571.94	00.00	30,856,571.94
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,617,929.00	179,479,097.57	247,111,543.26	00.00	695,208,569.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	416,591,202.00	505,748,177.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,349,000.00	13,800,000.00
122	Тусламжийн орлого	4,349,000.00	13,800,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	4,349,000.00	13,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,242,202.00	491,948,177.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,861,902.00	50,193,977.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,366,000.00	3,198,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,260,902.00	39,408,977.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,235,000.00	7,587,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	390,380,300.00	441,754,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	390,380,300.00	441,754,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	404,615,202.00	443,474,216.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,615,202.00	443,474,216.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,421,212.00	424,211,073.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,489,383.90	249,039,096.14
210101	Үндсэн цалин	180,803,256.75	171,646,647.94
210102	Нэмэгдэл	53,997,604.19	39,026,631.44
210104	Урамшуулал	7,177,840.00	12,695,262.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,510,682.96	25,670,554.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,916,325.10	32,193,500.00
210201	Тэтгэврийн даатгал	20,392,203.60	22,317,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,387,331.65	2,469,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,903,145.10	1,975,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	475,786.55	493,900.00

210205	Эрүүл мэндийн даатгал	4,757,858.20	4,937,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,074,324.00	17,365,022.00
210301	Гэрэл, цахилгаан	5,288,317.00	6,661,512.00
210302	Түлш, халаалт	11,786,007.00	10,643,510.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	60,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,827,018.00	26,191,252.00
210401	Бичиг хэрэг	8,153,900.00	4,589,330.00
210402	Тээвэр, шатахуун	21,138,118.00	17,410,402.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,145,000.00	2,300,000.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,270,000.00	1,771,520.00
2105	Нормативт зардал	3,450,580.00	6,560,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,199,000.00	6,560,000.00
210502	Хоол, хүнс	2,251,580.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,247,137.00	30,281,932.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	501,700.00	4,840,300.00
210602	Тавилга	00.00	121,100.00
210604	Урсгал засвар	4,745,437.00	25,320,532.00
2107	Томилолт, зочны зардал	1,158,344.00	1,962,262.50
210702	Дотоод албан томилолт	1,158,344.00	1,962,262.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,524,100.00	57,273,371.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,524,100.00	57,273,371.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,734,000.00	3,344,637.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,734,000.00	3,344,637.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,193,990.00	19,263,143.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,559,330.00	16,511,420.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,751,980.00	5,953,320.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	5,878,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,043,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,764,050.00	4,679,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,634,660.00	2,751,723.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,634,660.00	2,751,723.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>11,976,000.00</u>	<u>62,273,961.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>11,976,000.00</u>	<u>62,273,961.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>11,976,000.00</u>	<u>62,273,961.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>11,976,000.00</u>	<u>62,273,961.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,976,000.00	62,273,961.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-11,976,000.00</u>	<u>-62,273,961.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,754,200.00	440,158,476.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,754,200.00	440,158,476.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,242,700.00	423,647,056.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,921,900.00	244,865,096.14
210101	Үндсэн цалин	171,222,000.00	171,190,647.94
210102	Нэмэгдэл	39,322,800.00	39,026,631.44
210104	Урамшуулал	11,426,400.00	10,815,262.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,950,700.00	23,832,554.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,193,500.00	32,193,500.00
210201	Тэтгэврийн даатгал	22,317,100.00	22,317,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,469,300.00	2,469,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,975,400.00	1,975,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	493,900.00	493,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,937,800.00	4,937,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,870,000.00	17,365,022.00
210301	Гэрэл, цахилгаан	7,160,000.00	6,661,512.00
210302	Түлш, халаалт	10,650,000.00	10,643,510.00
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	60,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,566,000.00	21,565,930.00
210401	Бичиг хэрэг	4,689,400.00	4,689,330.00
210402	Тээвэр, шатахуун	12,700,000.00	12,695,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,290,000.00	2,290,000.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,766,600.00	1,771,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,422,300.00	41,417,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,200,000.00	15,195,080.00
210602	Тавилга	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	25,722,300.00	25,722,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,680,000.00	1,680,000.00
210702	Дотоод албан томилолт	1,680,000.00	1,680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,241,000.00	61,215,491.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,241,000.00	61,215,491.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3348000.00	3344637.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,348,000.00	3,344,637.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16511500.00	16511420.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,511,500.00	16,511,420.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,953,400.00	5,953,320.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,398,100.00	5,878,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,160,000.00	4,679,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,754,200.00	440,158,476.74

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	441,754,200.00	440,158,476.74
132001	Орон нутгийн төсвөөс	441,754,200.00	440,158,476.74
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00
620004	Гэрээт ажилтан	03.00	03.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,837,977.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,837,977.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,837,977.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,174,000.00
210101	Үндсэн цалин	456,000.00
210104	Урамшуулал	1,880,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,838,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,725,322.00
210402	Тээвэр, шатахуун	4,715,322.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,000.00
2105	Нормативт зардал	6,560,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,560,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,698,893.00
210604	Урсгал засвар	45,698,893.00
2107	Томилолт, зочны зардал	282,262.50
210702	Дотоод албан томилолт	282,262.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,397,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,397,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49037977.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,037,977.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,198,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,408,977.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,431,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IV)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Монгол улсын үндсэн хууль, бусад хууль аймаг сумын удирдлагын бодлогыг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан төр иргэний харилцааг ил тод нээлттэй болгож, иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлэн үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд манай хамт олны эрхэм зорилго оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 356.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31.2 сая төгрөг буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	1.4	1.4
Бараа материал	23.0	25.0	2.0
Үндсэн хөрөнгө	641.8	669.6	27.8
Нийт хөрөнгө	664.8	696.0	31.2
Өр төлбөр	0.4	0.8	0.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	664.4	695.2	30.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	664.8	696.0	31.2

Авлага дансны үлдэгдэл 1.4 сая төгрөг байгаа нь 0.2 сая төгрөг шатахууны, 1.2 сая төгрөгийн цалин хөлс 12 сарын 31-нд орж ирсэнтэй холбоотой тайлант онд зарцуулаагүй төсөвт төвлөрүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25.0 сая төгрөг болж, 2.0 сая төгрөгөөр өссөн нь ковид-19 цар тахлын үед онцгой комиссын нөөц бүрдүүлэлтийн материалын үлдэгдэл нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансанд нийт 34 нэр төрлийн 274.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 01 сарын 21-ний өдрийн 3 дугаар тогтоолоор 1 нэр төрлийн 80.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 68.6 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 695.2 сая төгрөг болж 30.8 сая төгрөгөөр өссөн байна.

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 132.5 сая төгрөг буюу 32.5 хувиар өссөн байна. Энэ нь нэмэлт санхүүжилтийн орлого 28.3 сая, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 51.4 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 43.3 сая, хандив тусламжийн орлого 9.4 сая төгрөгөөр өссөн тус тус нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 101.0 сая төгрөг буюу 24.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал засварын зардал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд 365.6 сая, багийн урсгал зардалд 49.4 сая, нийт 415.0 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 37.4 сая төгрөгөөр буурч 328.2 сая, багийн урсгал зардалд 49.4 сая төгрөг баталсан байна. Төсвийн тодотголоор 64.1 сая төгрөгөөр өсөж, 392.4 сая төгрөгөөр батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээнд улсын төсвөөс 441.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас тайлант хугацаанд 441.7 сая төгрөгийн санхүүжилт авч 440.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 1.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 42.6, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 13.8, туслах үйл ажиллагааны орлогоос 7.6, нийт 64.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Асгат сумын нэг цэгийн үйлчилгээний дулааны шугам сүлжээний урсгал засварын зардалд 38.6, наадмын талбайн засварын ажилд 7.0, худгийн усны төлбөрт 4.2, ковид 19 цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор эм, эмийн бэлдмэл, тээвэр, шатахууны зардал зэрэгт 13.0, нийт 62.8 сая төгрөгийг зарцуулж, 1.2 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд сумын Засаг даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулж 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.6 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Асгат сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа хоцорсон 2, хугацаандаа оруулсан 149 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгууртай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой зөрчил илрээгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17.6 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийн 1 алдаа зөрчлийг залруулж, 1 алдаа зөрчилд албан шаардлага, 4 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд 151 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нийт 567.5 сая төгрөгийн 22 мэдээллийг ил тод байршуулахаас 555.7 сая төгрөгийн 20 мэдээллийг ил тод байршуулаагүй, мэдээллийг байхгүйгээр мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 102 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжид дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дээд шатны байгууллага болон эрх бүхий этгээд дотоод хяналтын журмыг батлаагүй бол Засгийн газрын 2011 оны “НИЙТЛЭГ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

3. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 16 нэр төрлийн 11.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэж дансны үлдэгдэл, тодруулгын батламж мэдэгдлийг хангаагүй байна. Энэ нь УСНББОУС-ын "17-Үндсэн хөрөнгө" дахь 12-ын (а,б) заалт, НББ тухай хууль /19.1.2 батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;/ Төсвийн тухай хууль/ 26.1.Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө/ гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэлтэй 6 нэр төрлийн 6.3 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, шилжүүлэн бүртгэж зөрчлийг арилгах

4. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт

Бараа материалын тайланд 5.0 сая төгрөгийн дансны үнэтэй 45 хуц бүртгэгдсэн боловч бодитоор байхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Бодитоор байхгүй 45 хуцны асуудлын эзэн холбогдогчийг тогтоон, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж данс бүртгэлээс хасах;

Дээрх зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын Тамгын газар	6	17.6	1	1.5	0	0.0	1	0	4	16.1